

Гэрээ байгуулсан огноо:

2015 оны сарын өдөр

Улаанбаатар хот

Энэ гэрээг нэг талаас **2560526** регистрийн дугаартай Монгол улсын хуулийн этгээд болох **"MSM Group" ХХК** ("түрээслүүлэгч" гэх), нөгөө талаас регистрийн дугаартай Монгол улсын хуулийн этгээд ("түрээслэгч", хамтад нь "Талууд" гэх) нар дараах нөхцлүүдийг харилцан тохиролцож байгуулав.

НЭГ. ГЭРЭЭНИЙ ЗҮЙЛ

1.1. Энэ гэрээгээр Түрээслүүлэгч нь сериал дугаар бүхийтөхөөрөмжийг ("төхөөрөмж" гэх) түрээсээр ашиглуулах, Түрээслэгч нь гэрээнд заасны дагуу зохих төлбөрүүдийг төлөх, төхөөрөмжийг хэвийн байдлаар буцаан өгөхтэй холбогдон үүсэх харилцааг зохицуулна.

1.2. Төхөөрөмж нь Түрээслүүлэгчийн өмчлөлд байх бөгөөд гэрээний хүчин төгөлдөр хугацаанд төхөөрөмжийн зөвхөн ашиглах эрхийг Түрээслэгчид олгоно.

1.3. Талууд онцгой нөхцөлд харилцан тохиролцсоны үндсэн дээр гэрээний нөхцөл, заалтуудад нэмэлт өөрчлөлт оруулж болох ба уг нэмэлт, өөрчлөлтийг нэмэлт гэрээ байгуулж баталгаажуулна.

1.4. Гэрээний өргөдлийн маягт, нэмэлт гэрээ, шалгах хуудас нь энэ гэрээний салшгүй хэсэг байх бөгөөд тэдгээр нь энэ үндсэн гэрээний хугацаагаар хүчин төгөлдөр байна.

ХОЁР. ГЭРЭЭНИЙ ХУГАЦАА

2.1. Энэ гэрээ нь Түрээслэгч түрээсийн нөхцлийг хүлээн зөвшөөрч, Талуудын эрх бүхий этгээд гарын үсэг зурж, тамга тэмдэг даран баталгаажуулснаар хүчин төгөлдөр болж, төхөөрөмжийг түрээслэгчид хүлээлгэн өгснөөс хойш хоногийн хугацаанд хүчинтэй байна.

2.2. Энэ гэрээний 7.5-д заасан нөхцөл бүрдсэн тохиолдолд гэрээний хугацааг 2 талын тохиролцсон хугацаагаар эсвэл 2.1-д заасан хугацаагаар сунгагдсанд тооцно.

2.3. Түрээсийн гэрээний хугацаанд энэ гэрээний 2.1, 2.2-т заасан хугацаа, төхөөрөмжийг түрээслэгчийн ажлын талбарт хүргэх, түрээслүүлэгчийн байранд авч ирэх хугацаа орно.

ГУРАВ. ТҮРЭЭСЛЭГЧИЙН ЭРХ ҮҮРЭГ

3.1. Түрээслэгч нь төхөөрөмжийг түрээслүүлэгчээс өгсөн зааврын дагуу ашиглах бөгөөд уг төхөөрөмжийг зохих дадлага туршлагатай ажилтанд хариуцуулна.

3.2. Түрээсийн төлбөрийг цаг хугацаандаа төлж байх ба Төхөөрөмжийг түрээсийн гэрээнд заасан хугацаанд хэвийн ажиллагаатайгаар бүрэн бүтнээр хүлээлгэн өгнө.

3.3. Түрээслэгч нь Төхөөрөмжийг өмчлөх, засварлах, хийцийн өөрчлөлт оруулах болон захиран зарцуулах эрхгүй.

3.4. Түрээслүүлэгч төхөөрөмжийн гэрээнд заасан байршлийг солих тохиолдолд түрээслүүлэгчид 3 хоногийн өмнө урьдчилан бичгээр мэдэгдэх үүрэгтэй. Түрээслэгч хэрэв мэдэгдээгүй бол үүнтэй холбогдон гарах хохирлыг түрээслүүлэгчид төлөх үүрэгтэй.

3.5. Түрээслэгч Төхөөрөмжид урьдчилан сэргийлэх техник үйлчилгээг төхөөрөмжийн мото цагийн тоолуурт үндэслэн 500 мото цаг тутамд үнэ төлбөргүй хийлгэх эрхтэй. Урьдчилан сэргийлэх техник үйлчилгээний захиалгыг 3 өдрийн өмнө түрээслүүлэгчид мэдэгдэнэ.

3.6. Түрээслэгч төхөөрөмжид аливаа эвдрэл гэмтэл, осол гарсан тохиолдолд түрээслүүлэгчид 24 цагийн дотор мэдэгдэнэ. Түрээслүүлэгчийн эрх бүхий төлөөлөгчид ирж осол гэмтлийн шалтгааныг тогтоотол уг төхөөрөмжийг ослын газраас хөдөлгөхгүй байлгана.

3.7. Түрээслэгч нь энэ гэрээнд заасны дагуу түрээслүүлэгчийг эрхээ хэрэгжүүлэхэд нь аливаа саад учруулахгүй байх үүрэгтэй.

3.8. Түрээслэгч нь төхөөрөмжийн тээвэрлэлтийг бие даан хариуцах бөгөөд 13,973,800 үнийн дүнгээр даатгуулсан байна. Төхөөрөмжийн бүрэн бус найдваргүй байдал, тээвэрлэгчийн болгоомжгүй байдлаас болж төхөөрөмжид учирсан аливаа эвдрэл гэмтлийг түрээслэгч бие даан хариуцна.

3.9. Түрээслэгч нь энэ гэрээний үүргийн дагуу төлөх төлбөрүүдийн нэхэмжлэхийг хүлээн авсанаар түрээсийн хугацаа эхлэхээс өмнө түрээсийн төлбөрийг Түрээслүүлэгчид бүрэн төлнө.

3.10. Түрээслэгч нь гэрээний 5.3 заалтын дагуу хийгдсэн актыг үндэслэн эвдрэл гэмтэл болон иж бүрдэл дутуу зүйлсийн хохирлыг Түрээслүүлэгчид төлнө.

3.11. Түрээслэгч оператор хөрсөлсөн тохиолдолд операторын цагийн төлбөр 35,000 төгрөг байна. Үүнд НӨАТ ороогүй. Операторын

төлбөрийг ажил дуусаад, түрээслэгч нь төхөөрөмжийг буцааж түрээслүүлэгчийн байранд авчирсан өдөр төлнө.

ДӨРӨВ. ТҮРЭЭСЛҮҮЛЭГЧИЙН ЭРХ, ҮҮРЭГ

4.1. Төхөөрөмжийг ашиглах зааварчилгааг түрээслэгчид өгнө.

4.2. Түрээслүүлэгч нь түрээслэгчээс Төхөөрөмжийн байдал, ашиглаж буй нөхцөл, түүнийг ажиллуулж буй цаг, ачааллын байдалтай газар дээр нь танилцах эрхтэй.

4.3. Төхөөрөмж Түрээслэгчийн ашиглалтын буруугаас шалтгаалахгүйгээр ажиллагаагүй болвол түрээслүүлэгч аль болох богино хугацааны дотор түүнийг засварлан, хэвийн ажиллагаатай болгоно. Төхөөрөмжийн ажиллагаагүй болсныг хоёр талын актаар тогтооно.

4.4. Түрээслүүлэгчийн буруугаас Төхөөрөмжийн сул зогсолтын хугацаанд алдагдсан хохирлыг түрээслүүлэгч хариуцахгүй. Түрээслүүлэгчийн буруугаас Төхөөрөмж сул зогссон өдрүүдэд түрээсийн төлбөр ноогдуулахгүй

4.5. Түрээслэгч нь өдөр, долоо хоног, 28 хоногийн аль нэг хугацаагаар түрээсийн гэрээ байгуулан төхөөрөмжийг авч ашигласан боловч уг хугацаанд бодитоор ажилласан цаг нь суурь үнэлгээний цагт хүрээгүй тохиолдолд анх гэрээ хийгдсэн сүүр үнэлгээгээр төлбөрийг тооцож авна.

4.6. Түрээслүүлэгч нь Төхөөрөмжид урьдчилан сэргийлэх техник үйлчилгээг өөрийн зардлаар хийнэ. Энэ үйлчилгээнд тогтоосон мото цаг тутамд хийх техник үйлчилгээ болон тос, тосолгооны шингэн, жижиг эд ангиудыг солих зэрэг хамаарна.

4.7. Түрээслүүлэгч Төхөөрөмжийг түрээслэгчид шилжүүлэн өгөхдөө түлшний савыг 100% цэнэглэж өгнө.

4.8. Түрээслэгчийн аливаа буруутай үйл ажиллагаанаас болж төхөөрөмжид учирсан аливаа хохирлыг түрээслэгч бүрэн хариуцна. Үүнд тээвэрлэлт, ашиглалтын буруугаас үүдсэн хохирол орно.

4.9. Түрээслэгч нь энэ гэрээний 7.5-т заасны дагуу гэрээг сунгаагүй бол төхөөрөмжийг хугацаандаа эргүүлэн өгөхийг түрээслэгчээс шаардах эрхтэй.

4.10. Түрээслэгч нь түрээсийн төлбөрийг хугацаанд нь төлж гэрээг сунгаагүй бол түрээслүүлэгч нь хэдийд ч төхөөрөмжийг зогсоон өөрийн байранд авч ирэх эрхтэй бөгөөд холбогдон гарах зардлыг (НӨАТ-ын хамт) түрээслэгч талаас нэхэмжлэнэ.

4.11. Түрээслэгч нь Төхөөрөмж болон Түрээслүүлэгчийн эрх ашгийг ноцтойгоор зөрчиж байгаа үед түрээслүүлэгч хэдийд ч төхөөрөмжийг зогсоон өөрийн байранд авч ирэх эрхтэй бөгөөд үүнтэй холбогдон гарах бүх зардлыг түрээслэгчээс гаргуулна.

4.12. Түрээслэгч нь төхөөрөмжийг түрээслүүлэгчийн байрнаас өөрийн ажлын талбар хүртэл болон буцаан түрээслүүлэгчийн байранд тээвэрлэн авч ирэх 2 талын зардлыг бүрэн хариуцна.

ТАВ. ТӨХӨӨРӨМЖ ХҮЛЭЭЛЦЭХ ЖУРАМ

5.1. Талуудын төлөөлөгч нар төхөөрөмжийг шалгаж түүний бүрэн бүтэн байдал, ажиллагаа, иж бүрдлийн тухай шалгах хуудсанд тэмдэглэнэ. Төхөөрөмжийг хүлээлцэх тухай шалгах хуудсанд төлөөлөгч нар гарын үсэг зурснаар Төхөөрөмжийг хүлээлцсэнд тооцно. Төхөөрөмжийг хүлээн авах, хүлээлгэн өгөхөд түрээслэгч өөрийн эрх бүхий төлөөлөгч томилно. Хэрэв түрээслэгч талаас төхөөрөмжийг хүлээлцэхэд төлөөлсөн хүн ирээгүй тохиолдолд тухайн төхөөрөмжийг хүлээлцсэнд тооцож шалгах хуудсыг бөглөнө.

5.2. Түрээслэгч уг гэрээ болон гэрээний хавсралт болох шалгах хуудсанд гарын үсэг зурж төхөөрөмжийг зохих хугацаанд нь буцаан өгөх үүрэг хүлээснээ нотлоно.

5.3. Түрээслүүлэгч Төхөөрөмжийг хүлээн авах үедээ түрээслэгчийн төлөөлөгчийг байлцуулан төхөөрөмжд техникийн үзлэг хийнэ. Хэрэв ийнхүү хүлээн авах үед төхөөрөмж эвдрэл гэмтэлтэй, иж бүрдэл дутуу байвал энэ тухай хоёр талын төлөөлөгч нар акт үйлдэж гарын үсэг зурна.

5.4. Төхөөрөмжийг буцаан өгсөн өдрийг шалгах хуудас хаагдсан өдрөөр тооцно.

5.5. Түрээслэгч төхөөрөмжийг буцаан өгөхдөө зохих цэвэрлэгээг хийж, түлшний савыг 100% дүүргэсэн байна.

5.1. Түрээслэгч Төхөөрөмжийг ажлын цагаар хүлээлгэж өгнө.

ЗУРГАА. ТӨХӨӨРӨМЖ АШИГЛАХ, ХАДГАЛАХ ЖУРАМ

6.1. Түрээслэгч түрээсийн хугацаанд Төхөөрөмжийг түрээслүүлэгчээс өгсөн зааврын дагуу зөв ашиглаж, ажлын бус үед найдвартай хадгалж байх үүрэгтэй.

6.2. Түрээслэгч ажилчныг осол аварта орох, төхөөрөмжийн эвдэрч гэмтэх эрсдлийг бууруулах үүднээс зөвхөн түүнийг ажиллуулах зохих дадлага туршлагатай мэргэжлийн бөгөөд шаардлагатай тохиолдолд тусгай эрх бүхий хүнээр ажиллуулна. Мөн тоног төхөөрөмжийг найдвартай тээвэрлэх, ажиллуулахад шаардлагатай бусад бүх урьдчилан сэргийлэх арга хэмжээг авч ажиллана.

6.3. Түрээслэгч нь өдөр бүр Төхөөрөмжид эвдрэл гэмтэл гарсан эсэх, тос шингэний алдагдал байгаа эсэхийг шалгана. Түрээслэгч нь өдөр бүр тосолгооны цэгүүдийг өөрийн зардлаар тосолж байна. Түрээслэгч нь төхөөрөмжид зөвхөн түрээслүүлэгчийн заасан зориулалтын тосолгооны материал ашиглах бөгөөд өөр нэр төрлийн тос, шингэн ашигласнаас шалтгаалж гарсан аливаа эвдрэл гэмтлийг түрээслэгч өөрийн зардлаар хариуцна.

ДОЛОО. ТҮРЭЭСИЙН ТӨЛБӨР

7.1. Төхөөрөмжийг хүлээлгэн өгөхөөс өмнө түрээсийн төлбөрийг бэлнээр эсвэл шилжүүлгээр хийсэн байна.

7.2. Төхөөрөмжийн түрээсийн төлбөр нь **хоногийн суурь үнэлгээ буюу** **мото цагт** **төгрөг байна** /Үүнд НӨАТ ороогүй/

7.3. Түрээслэгч нь төлбөрийг нэхэмжлэх дээр байгаа банкны данс руу шилжүүлнэ.

7.4. Төхөөрөмжийг түрээсийн хугацаанд илүү мото цагаар ажиллуулсан бол Илүү цагийн үнэ/цаг хоногийн суурь үнэлгээ буюу мото цагаас илүү гарах мото цаг болгонд төгрөг бодогдоно.

7.5. Түрээслэгч нь түрээсийн хугацааг сунгахаар бол түрээслүүлэгчид 3 хоногийн өмнө бичгээр урьдчилан мэдэгдэнэ. Түрээслэгч нь гэрээг сунгахаас өмнө урьдах хугацааны түрээстэй холбоотой төлбөрүүдийг болон сунгалтын төлбөрийг төлнө. Хэрэв түрээсийн үед илүү цагийн төлбөр гарсан бол тухайн түрээсийн хугацаанд гарсан илүү цагийн төлбөрийг түрээсийн сунгалтын төлбөртэй хамт барагдуулна.

1. Гэрээг 28 өдрөөр сунгах бол /160 мото цаг/ илүү цаг ₮.....

2. Гэрээг 7 хоног сунгах бол ₮ /40 мото цаг/ илүү цаг ₮.....

3. Гэрээг 1 хоног сунгах бол ₮..... /8 мото цаг/ илүү цаг ₮.....

4. Дээрх үнэ нь манай түрээсийн номонд байгаа стандарт үнэ байна/

7.6. Түрээслэгч төхөөрөмжийг түрээсийн сүүлийн хугацаанаас өмнө хүлээлгэн өгсөн тохиолдолд түрээслүүлэгч ашиглаагүй хугацааны түрээсийн төлбөрийгхоногийн суурь үнэлгээгээр тооцож авна.

7.7. Түрээслэгч нь түрээсийн хугацааны эцэст түрээслүүлэгчид төлбөртэй гарвал түрээслүүлэгчийн нэхэмжлэх авснаас ажлын 3 хоногийн дотор төлбөрийг барагдуулна. Түрээсийн хугацааны эцэст Түрээслэгч нь түрээслүүлэгчээс авлагатай гарвал түрээслүүлэгч нь төлбөрийг ажлын 3 өдөрт хийж гүйцэтгэнэ.

НАЙМ. БАРЬЦАА ТӨЛБӨР

8.1. Түрээслэгч нь төхөөрөмжийг түрээслэн ашиглах хугацаандаа барьцаа төлбөр төлөх ба барьцаа төлбөрийн дүн нь ₮ байх ба түрээсийн хугацаанаас хамааран түрээсийн төлбөрийн эхний 28 өдрийн, 7 хоногийн, 1 өдрийн дүнтэй тэнцүү байх ба барьцаа төлбөрийг Төхөөрөмж түрээслэж эхлэх хугацаанаас өмнө Түрээслүүлэгчид төлсөн байна. Барьцаа төлбөрийн дүн 28 өдрийн түрээсийн төлбөрөөс хэтрэхгүй байна.

8.2. Барьцаа төлбөрийг түрээслэгч түрээслүүлэгчид төхөөрөмжийг бүрэн бүтэн хүлээлгэн өгч бусад тооцоо нийлснээр чөлөөлнө.

ЕС. ХАРИУЦЛАГА

9.1. Түрээслэгч нь төхөөрөмжийн моторын цагийн тоолуурыг зогсоон оролдсон, буцаасан аливаа тохиолдолд түрээслүүлэгч энэ гэрээг тэр дор нь цуцлаж, төхөөрөмжийг өөрийн байранд буцаан өгөхийг түрээслэгчээс шаардах буюу өөрийн зардлаар төхөөрөмжийг буцаан авч ирж холбогдон гарсан зардлыг түрээслэгчээр нөхөн төлүүлнэ.

9.2. Түрээслэгч нь төхөөрөмжийн моторын цагийн тоолуурыг зогсоон оролдсон, буцаасан тохиолдолд уг төхөөрөмжийн ашигласан хугацааны турш хоногт 24 цаг ашигласан гэж үзэн түүнд ногдох төлбөрийг түрээслэгчээр төлүүлнэ.

9.3. Түрээслэгч төхөөрөмжийг буцаан өгөх хугацаанд гэрээнд зааснаас хожимдуулсан тохиолдолд түрээслэгч гэрээний хугацаа дууссан өдрөөс эхлэн төхөөрөмжийг буцаан өгөх хүртэл хугацаанд хоцроосон хоног тутамд түрээсийн нэг өдрийн суурь үнэлгээгээр төлүүлнэ. Хугацаа 5 хоногоор хэтэрсэн тохиолдолд түрээслүүлэгч нь машиныг буцаан авч, түрээслүүлэгчийн байранд авч ирэх зардал болон бусад бүх холбогдолтой зардлыг түрээслэгчээс гаргуулан авах эрхтэй.

9.4. Түрээслэгч нь түрээсийн төлбөр болон түрээсийн илүү цагийн хөлс, тээврийн зардал болон бусад холбогдох төлбөрийг энэ гэрээний 3.9-д заасан хугацаанд төлөөгүй бол хугацаа хоцроосон хоног тутам төлөгдөөгүй үнийн дүнгийн 0.2%-тай тэнцэх хэмжээний алданги нэмж төлнө.

9.5. Төхөөрөмжид гарсан аливаа эвдрэл гэмтлийн улмаас зогссон өдрийг түрээслүүлэгчид мэдэгдсэн өдрөөс тооцно.

9.6. Түрээслэгч төхөөрөмжийг хүлээлгэн өгөхдөө түлшний савыг түлшээр 100% хүртэл цэнэглээгүй тохиолдолд 1 литр түлшийг 3000 төг-өөр бодож нэхэмжлэнэ /НӨАТ ороогүй/.

АРАВ. ДАВТАГДАШГҮЙ ХҮЧИН ЗҮЙЛ

10.1. Холбогдох хууль тогтоомжид заасан гэнэтийн давагдашгүй хүчин зүйлийн улмаас талуудын аль нэг нь гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй бол нөгөө талдаа ажлын гурав хоногийн дотор бичгээр мэдэгдэх ба энэ тохиолдолд үүрэг гүйцэтгэх хугацаа нь энэ нөхцөл байдал үргэлжлэх хугацаагаар хойшлогдоно. Уг хугацаа нь хуанлийн нэг сараас дээш үргэлжилсэн тохиолдолд талууд тохиролцон гэрээнд өөрчлөлт оруулж болно.

АРВАН НЭГ. МАРГААН ШИЙДВЭРЛЭХ

11.1. Энэ гэрээтэй холбоотой гарч болзошгүй бүх санал зөрөлдөөн, маргааныг талууд харилцан зөвшилцөх замаар шийдвэрлэнэ. Санал зөрөлдөөн, маргааныг зөвшилцөөнөөр шийдвэрлэж чадаагүй бол санал зөрөлдөөн маргааныг Монгол улсын хууль тогтоомжид заасны дагуу шүүхээр шийдвэрлүүлнэ.

АРВАН ХОЁР. БУСАД НӨХЦӨЛ

12.1. Гэрээнд зөвхөн талуудын харилцан тохиролцсоны үндсэн дээр бичгээр нэмэлт, өөрчлөлт оруулна. Гэрээг сунгах, өөрчлөх болон цуцлах саналыг нөгөө талдаа 3 хоногийн өмнө бичгээр мэдэгдэнэ.

12.2. Энэ гэрээг монгол хэл дээр хоёр эх хувь үйлдэх бөгөөд талууд нэг нэг хувийг хадгална.

12.3. Нөгөө талын бичгээр өгсөн зөвшөөрөлгүйгээр өөрийн эрх үүргийг гуравдагч этгээдэд аль нэг тал шилжүүлэх эрхгүй.

12.4. Түрээслэгчийн төлөөлөн удирдах зөвлөл, гүйцэтгэх захирал, өмчлөгч үүсгэн байгуулагчид өөрчлөгдсөнөөс үл хамааран энэ гэрээ хүчин төгөлдөр байна.

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

ТҮРЭЭСЛҮҮЛЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

Төхөөрөмжийн түрээс хариуцсан ажилтан:

.....

/овог нэр, гарын үсэг/

Салбарын захирал:

.....

/овог нэр, гарын үсэг/

Тамга:

Хаяг: Монгол улс, Улаанбаатар хот,
Хан-Уул дүүрэг, 3-р хороо, Чингисийн өргөн чөлөө 62

ТҮРЭЭСЛЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

Албан тушаал:

.....

/овог нэр, гарын үсэг/

.....

Хаяг: